



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн бүртгэлд  
2023 оны 08 сарын 29-ны  
өдрийн 6386 дугаарт бүртгэв.

2023 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/295

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 10, 3.3 дугаар зүйлийн 1, 2 дугаар хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.9, 25.13, 25.15 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах, багц цаг тооцох, зөвшөөрлийн гэрчилгээ олгох, нөхөн олгох журам"-ыг нэгдүгээр, "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгох журам"-ыг хоёрдугаар, "Зөвшөөрөл хүсэхэд бүрдүүлэх баримт бичиг"-ийг гуравдугаар, "Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний загвар"-ыг дөрөвдүгээр, "Гадаадын эмнэлгийн мэргэжилтний танилцуулгын маягт"-ыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах зорилгоор Зөвшөөрлийн тухай хуулийн Гуравдугаар бүлгийн 3.2 дугаар зүйлийн 1.2, 1.3, 2.3, 2.5-2.9, Тавдугаар бүлгийн 5.1, 5.2 дугаар зүйл, 5.3 дугаар зүйлийн 2, 3, 8, 9 дэх хэсэг, 5.4, 5.5 дугаар зүйл, Зургадугаар бүлгийн 6.1, 6.2, 6.3 дугаар зүйлд заасныг зохицуулах эрхийг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д шилжүүлэн олгосугай.

3. Тушаалыг нийт эрүүл мэндийн байгууллагад сурталчлан таниулах, хэрэгжилтэд арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар /П.Оюунцэцэг/-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д тус тус даалгасугай.

4. Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /С.Эрдэнэтуяа/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т тус тус үүрэг болгосугай.


5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



*S. Chinzorig*

С.ЧИНЗОРИГ



111224281

Эрүүл мэндийн сайдын 2023 оны  
08 дугаар сарын 11-ны өдрийн  
А/295 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

## ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, БАГЦ ЦАГ ТООЦОХ, ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ, НӨХӨН ОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (цаашид "зөвшөөрөл" гэх)-тэй холбоотой үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, энэхүү журам болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.
- 1.2. Энэхүү журмаар зөвшөөрөлтэй холбоотой дараах харилцааг зохицуулна:
  - 1.2.1. зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт
  - 1.2.2. зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах;
  - 1.2.3. багц цаг бүрдүүлэх, тооцох;
  - 1.2.4. зөвшөөрлийн гэрчилгээ олгох, нөхөн олгох.
- 1.3. Энэхүү журам нь Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасны дагуу хүний их эмч, уламжлалт анагаах ухааны их эмч, шүдний их эмч, эм зүйч, эм найруулагч, сувилагч, бага эмч, эх баригч, сэргээн засах чиглэлийн мэргэжилтнээр ажиллаж байгаа болон анагаах ухааны боловсрол олгох дотоод, гадаадын их, дээд сургууль, коллеж төгсөж, эзэмшсэн мэргэжлийн дагуу ажиллах гэж буй эмнэлгийн мэргэжилтэнд хамаарна.
- 1.4. Зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд Зөвшөөрлийн тухай хуулийн Нэгдүгээр бүлгийн 1.5 дугаар зүйл, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 5 дугаар зүйл, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмыг тус тус баримтална.
- 1.5. Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.14 дэх хэсэгт заасан орон тооны бус зөвлөл (цаашид "Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөл" гэх) нь зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангана.
- 1.6. Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр байгуулна.
- 1.7. Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.13 дахь хэсэгт заасны дагуу эрх олгосон төрийн байгууллага (цаашид "Эрүүл мэндийн хөгжлийн төв" гэх) нь Зөвшөөрлийн тухай хуулийн 5, 6 дугаар бүлэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 25

дугаар зүйлийн 25.13 дахь хэсэгт заасанчлан зөвшөөрөлтэй холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах бөгөөд зөвшөөрөл олгосон, сунгасан, нөхөн олгосон, түтгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон шийдвэрийг Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.17 дахь хэсэгт заасан эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд оруулж, Зөвшөөрлийн тухай хуулийн Долдугаар бүлгийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд тухай бүр бүртгүүлнэ.

1.8. Зөвшөөрөл олгох үйл ажиллагааны зардлын жишгийг Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.16 дахь хэсэгт заасны дагуу санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан журмаар зохицуулна.

1.9. Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.1-д заасан зөвшөөрөл бүхий резидент эмч нь сургалтын нэг жил аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт зохион байгуулах "Ерөнхий мэргэшил судлал" үндсэн мэргэшлийн сургалтад суралцаж ажиллана.

### **Хоёр. Зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт**

2.1. Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн асуудал хариуцсан нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. Зөвшөөрлийн тухай хуулийн Гуравдугаар бүлгийн 3.2 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх, зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааны хэрэгжилтийг зохицуулах;

2.1.2. зөвшөөрлийн эрх зүйн орчинг сайжруулах санал боловсруулж, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, шийдвэрлүүлэх;

2.1.3. Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллах;

2.1.4. зөвшөөрлийн асуудлаар Эрүүл мэндийн хөгжлийн төвд үйл ажиллагааны чиглэл, заавар өгч ажиллах;

2.1.5. зөвшөөрөлтэй холбоотой шийдвэрийн төслийг хянаж, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр батлуулах.

2.2. Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.2.1. зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн дэмжлэг үзүүлэх;


2.2.2. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн зөвшөөрөлтэй холбоотой тайланг жил тутам хэлэлцэх, зөвлөмж, үүрэг даалгавар, чиглэл өгөх.



- 2.2.3. зөвшөөрөлтэй холбоотой зөрчил гаргасан холбогдох албан тушаалтан, эмнэлгийн мэргэжилтэнд хариуцлага тооцох асуудлаар эрх бүхий албан тушаалтанд уламжилж, шийдвэрлүүлэх;
- 2.2.4. Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудалд хамаарах баримт бичгийг архивын хууль тогтоомжид заасны дагуу архивын нэгж үүсгэж, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хадгалуулах.
- 2.3. Эрүүл мэндийн хөгжлийн төв нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 2.3.1. эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтнээс ирүүлсэн зөвшөөрөлтэй холбоотой хүсэлтийг Зөвшөөрлийн тухай хуулийн 5, 6 дугаар бүлэгт заасны дагуу хүлээн авч, магадлан шалгаж, хуульд заасан хугацаанд хянаж шийдвэрлэх;
- 2.3.2. Зөвшөөрлийн тухай хуулийн Хоёрдугаар бүлгийн 2.3 дугаар зүйлд заасан зөвшөөрлийн кодтой уялдуулж Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.17 дахь хэсэгт заасны дагуу эмнэлгийн мэргэжилтэн бүрт зөвшөөрлийн дахин давтагдашгүй дугаар олгох;
- 2.3.3. эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийг үндэслэн зөвшөөрлийн гэрчилгээг батлагдсан загварын дагуу баталгаажуулж олгох, эрх бүхий албан тушаалтан, эмнэлгийн мэргэжилтэнд хүлээлгэн өгөх;
- 2.3.4. зөвшөөрлийн үйл ажиллагааг зохицуулах, зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах, зөвшөөрөл олгох, багц цаг бүрдүүлэх, тооцохтой холбоотой заавар, зөвлөмж гаргах, зөвшөөрлийн гэрчилгээний цээж зурагт тавигдах шаардлагыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын шийдвэрээр баталгаажуулах, шинэчлэх;
- 2.3.5. зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах төлөвлөгөө, тов, бүртгэлийн хугацаа, удирдамж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын шийдвэрээр баталгаажуулах, зөвшөөрлийн шалгалтын бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулах;
- 2.3.6. зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах, гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн санал, дүгнэлт гаргах чиглэлээр мэргэжлийн нийгэмлэг, холбоотой гэрээ байгуулах, хамтран ажилах, хэрэгжилтийг дүгнэх;
- 2.3.7. Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх асуудлыг боловсруулж, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн даргад танилцуулж, батлуулсаны үндсэн дээр журамд заасан хугацаанд багтаан хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;
- 2.3.8. зөвшөөрлийн шалгалтын сорилын санг бүрдүүлэх, үнэлгээ хийх, 30-аас доошгүй хувийг жил бүр шинэчилж, баяжуулах, сорилын сангийн нууцлалтай холбоотой гэрээг энэхүү журмын 2.7.2-т заасны дагуу байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллах;



- 2.3.9. эмнэлгийн мэргэжилтний жил бүр бүрдүүлэх багц цагийн бүрдүүлэлтэд хяналт тавих, тухайн жилд багц цаг бүрдүүлээгүй эмнэлгийн мэргэжилтэнд цахим мэдэгдэл хүргүүлэх, багц цаг бүрдүүлээгүй эмнэлгийн мэргэжилтний нэрсийг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, зөвшөөрлийг хүчингүй болгуулах;
- 2.3.10. зөвшөөрөл олгосон, сунгасан, нөхөн олгосон, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тохиолдолд эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн сан, зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, шинэчлэх;
- 2.3.11. зөвшөөрлийн шалгалт, багц цаг бүрдүүлэх, тооцохтой холбоотой мэдээлэл, зөвлөмжийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудаст байршуулах, тогтмол шинэчлэх, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллагуудад зөвлөгөө өгөх;
- 2.3.12. зөвшөөрлийн талаарх судалгаа, дүн шинжилгээ хийх, судалгааны мэдээллийн сан үүсгэх, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад судалгаа, дүн шинжилгээний тайланг хүргүүлэх;
- 2.3.13. дотоод, гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн талаарх статистик мэдээлэл, дүн шинжилгээ бүхий тайланг жил тутам нэгтгэн гаргаж, дараа жилийн нэгдүгээр сард багтаан эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудаст байршуулах;
- 2.3.14. эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрлийн лавлагаа, тодорхойлолтыг монгол, англи хэлээр цаасан эсхүл цахим хэлбэрээр гаргаж өгөх, шаардлагатай тохиолдолд гадаад улсын холбогдох байгууллагатай харилцаж, зөвшөөрөл хүссэн эмнэлгийн мэргэжилтний лавлагаа, тодорхойлолт, тодруулга авах;
- 2.3.15. гадаадын иргэний асуудал, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, хуулийн байгууллага, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын салбарын хяналтын асуудал хариуцсан нэгж, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо зэрэг холбогдох талуудтай хамтран ажиллах, лавлагаа, мэдээлэл харилцан солилцох, зөвшөөрөл олгосон гадаадын эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-үнэлгээг хамтран хийх;
- 2.3.16. зөвшөөрлийн асуудлаар эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтэн, иргэн, бусад хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг судалж шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагад уламжилж шийдвэрлүүлэх;
- 2.3.17. эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөл, холбогдох эрх бүхий байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоодоос өгсөн



санал, зөвлөмж, дүгнэлт, бусад шийдвэрийг тухай бүр хэрэгжүүлэх, эргэн мэдэгдэх;

2.3.18. анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллеж төгсөгчдийн болон эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн шалгалтын дүнг нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх;

2.3.19. холбогдох баримт бичгийг архивын хууль тогтоомжид заасны дагуу архивын нэгж үүсгэн хадгалах.

2.4. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.4.1. зөвшөөрлийн шалгалт, багц цаг бүрдүүлэхтэй холбоотой мэдээллээр эмнэлгийн мэргэжилтэнг хангах, төгсөлтийн дараах багц цагийн богино хугацааны сургалтыг орон нутгийн түвшинд мэргэжлийн нийгэмлэг, холбоотой хамтран зохион байгуулах;

2.4.2. Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд тогтмол баяжуулалт хийх, харьяалах эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн нэгтгэлийг орон нутгийн түвшинд улирал тутам гаргаж дүгнэх, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх.

2.5. Эрүүл мэндийн байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.5.1. хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй эмнэлгийн мэргэжилтэнг Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу зөвшөөрөл олгосон төрлөөр томилон ажиллуулах;

2.5.2. эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд эмнэлгийн мэргэжилтэн тус бүрийн зөвшөөрөл, сургалт, ажлын байр, оршин суух хаяг, бусад мэдээллийн өөрчлөлтийг тухай бүр бүртгэх;

2.5.3. зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг ил тод, нээлттэй байршуулах, эмнэлгийн мэргэжилтэн багц цаг бүрдүүлэх, төгсөлтийн дараах сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлэх;

2.5.4. зөвшөөрөл сунгуулах эмнэлгийн мэргэжилтний судалгааг улирал тутам гаргаж, зөвшөөрлийн хугацаа дуусгавар болохоос ажлын 50-аас доошгүй хоногийн өмнө эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл сунгуулах хүсэлт гаргах талаар сануулж мэдэгдэх;

2.5.5. зөвшөөрлийн шалгалтад орох эмнэлгийн мэргэжилтний үүрэгт ажлыг зохицуулах, дэмжлэг үзүүлэх.

2.6. Анагаах ухааны боловсрол олгох зөвшөөрөл бүхий дотоодын их, дээд сургууль, коллеж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.6.1. зөвшөөрөл анх удаа олгох төгсөгчдийн нэрсийн жагсаалтыг баталгаажуулж, диплом гардуулсанаас хойш ажлын 10 хоногт багтаан Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлэх;



- 2.6.2. зөвшөөрөлтэй холбоотой эрх зүйн орчны мэдээллийг төгсөгчдөд хүргэх;
- 2.6.3. төгсөгчдийн улсын шалгалт, зөвшөөрлийн шалгалтын үнэлгээнд харьцуулсан дүн шинжилгээ хийх, Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран ажиллах.
- 2.7. Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас эмнэлгийн мэргэжилтний мэргэшлийн зэргийн шалгалт зохион байгуулах эрх олгосон мэргэжлийн нийгэмлэг, холбоо, мэргэжлийн салбар зөвлөл (цаашид "мэргэжлийн нийгэмлэг, холбоо, мэргэжлийн салбар зөвлөл" гэх) нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 2.7.1. төгсөлтийн дараах багц цагийн богино хугацааны сургалт зохион байгуулах;
- 2.7.2. зөвшөөрлийн шалгалтын сорилыг холбогдох мэргэжлийн чиглэлээр боловсруулж, Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүлээлгэн өгөх, нууцлалтай холбоотой гэрээ байгуулах, гэрээг мөрдөх;
- 2.7.3. зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах, гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн талаар санал, дүгнэлт, зөвлөмж гаргах чиглэлээр Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй гэрээ байгуулах, гэрээг мөрдөх;
- 2.7.4. багц цаг бүрдүүлэх, зөвшөөрлийн шалгалтад орох эмнэлгийн мэргэжилтэнд арга зүйн дэмжлэг үзүүлэх;
- 2.7.5. гадаадын эмнэлгийн мэргэжилтний талаар мэргэжлийн санал, дүгнэлт, зөвлөмжийг тухай бүр гаргаж, Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлэх;
- 2.7.6. Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд үндэслэн холбогдох мэргэжлийн чиглэлээрх зөвшөөрлийн судалгааг улирал тутам нэгтгэн гаргах, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх.
- 2.8. Эмнэлгийн мэргэжилтэн нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 2.8.1. Зөвшөөрлийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлгийн 4.1 дүгээр зүйлд заасан нийтлэг нөхцөл, шаардлагыг хангаж, 4.2 дугаар зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээх;
- 2.8.2. хүчин төгөлдөр зөвшөөрлийн гэрчилгээтэй ажиллах, зөвшөөрлийн гэрчилгээг гээгдүүлж үрэгдүүлэхгүй хадгалах;
- 2.8.3. Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу зөвхөн зөвшөөрөл олгосон төрлөөр тусламж, үйлчилгээ үзүүлэх;
- 2.8.4. энэхүү журмын 4 дүгээр бүлэгт заасны дагуу багц цагийг жил тутам бүрдүүлж, тооцуулах, 5 жил тутам зөвшөөрлөө сунгуулах;



- 2.8.5. зөвшөөрлийн хүчин төгөлдөр хугацаа дуусгавар болохоос ажлын 30-аас доошгүй хоногийн өмнө зөвшөөрөл сунгуулах хүсэлтийг эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд цахимаар гаргах;
- 2.8.6. зөвшөөрлийн шалгалтад орох тохиолдолд Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зарласан бүртгэлийн хугацаанд багтаан эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд цахимаар хүсэлт гаргах, хугацаанд нь шалгалт өгөх;
- 2.8.7. зөвшөөрөл анх удаа авах төгсөгчийн хувьд диплом гардан авснаас хойш ажлын 5 хоногт багтаан эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд хүсэлт гаргаж, бүртгүүлэх;
- 2.8.8. зөвшөөрлийн шалгалтад тэнцэж зөвшөөрөл авах эрх үүссэн тохиолдолд шалгалтын дүн гарсанаас хойш ажлын 10 хоногт багтаан эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд хүсэлт илгээж, баталгаажуулах;
- 2.8.9. зөвшөөрлийн шалгалт, зөвшөөрлийн гэрчилгээтэй холбогдон гарах зардлыг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн гишүүдийн хамтран баталсан төлбөрийн жишгийн дагуу өөрөө хариуцан төлөх;
- 2.8.10. зөвшөөрөлтэй холбоотой санал, хүсэлт, өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх, зөвшөөрлийн лавлагаа, тодорхойлолтыг цахим эсхүл цаасан хэлбэрээр монгол, англи хэлээр Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс гаргуулж авах;
- 2.8.11. ажлын газар, оршин суух хаяг өөрчлөгдөх бүрт эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд бүртгүүлж, баталгаажуулах, өнгөт цээж зураг жил тутам шинэчилж оруулах.

### **Гурав. Зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах**

- 3.1. Зөвшөөрлийн шалгалтыг цахим хэлбэрээр авна.
- 3.2. Зөвшөөрлийн шалгалтыг мэдээллийн технологийн дэвшилтэт технологи, техник хэрэгслийг ашиглан зайн хэлбэрээр авч болно.
- 3.3. Зөвшөөрлийн шалгалтыг нэг болон олон хувилбарт сорилоор авна. Зөвшөөрлийн шалгалтад эмчилгээ, оношилгооны чиглэлээрх дүрс бичлэг, дуу авиа, зураг ашиглаж болно.
- 3.4. Зөвшөөрлийн шалгалтын агуулгыг дараах байдлаар тодорхойлно:
- 3.4.1. Анагаах ухааны их, дээд сургууль шинээр төгссөн хүний их эмчийн зөвшөөрлийн шалгалтын сорилын 65 хувь нь ерөнхий мэргэшлийн, 5 хувь нь төрөлжсөн мэргэшлийн анагаах ухааны, 20 хувь нь нийгмийн эрүүл мэндийн, 5 хувь нь эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль эрх зүйн, 5 хувь нь эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн асуултууд байна.
- 3.4.2. Анагаах ухааны их, дээд сургууль шинээр төгссөн уламжлалт анагаах ухааны их эмч, шүдний их эмчийн зөвшөөрлийн шалгалтын сорилын 70





хувь нь тухайн мэргэжлийн, 15 хувь нь нийгмийн эрүүл мэндийн, 5 хувь нь эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль эрх зүйн, 10 хувь нь эмнэлгийн мэргэжилтний ба анагаах ухааны ёс зүйн асуултууд байна.

3.4.3. Мэргэшсэн эмчийн зөвшөөрлийн шалгалтын сорилын 75 хувь нь үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн анагаах ухааны (төрөлжсөн мэргэшлээр суралцсан бол 20 хувь нь тухайн чиглэлээр), 10 хувь нь нийгмийн эрүүл мэндийн, 5 хувь нь эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль эрх зүйн, 10 хувь нь эмнэлгийн мэргэжилтний ба анагаах ухааны ёс зүйн асуултууд байна.

3.4.4. Эх баригч, эм зүйч, эм найруулагч, сувилагч, бага эмч, сэргээн засах чиглэлийн мэргэжилтний зөвшөөрлийн шалгалтын сорилын 75 хувь нь тухайн мэргэжлийн (төрөлжсөн мэргэшлээр суралцсан бол 20 хувь нь тухайн чиглэлээр), 10 хувь нь нийгмийн эрүүл мэндийн, 5 хувь нь эрүүл мэндийн салбар мөрдөгдөж буй хууль эрх зүйн, 10 хувь эмнэлгийн мэргэжилтний ба анагаах ухааны ёс зүйн асуултууд байна.

3.4.5. Гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн шалгалтын сорилыг монгол, англи хэлээр бүрдүүлэх ба сорилын 80 хувь нь тухайн төрөлжсөн мэргэшлийн, 10 хувь нь эмнэлгийн мэргэжилтний ба анагаах ухааны ёс зүйн, 10 хувь нь Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль болон бусад хууль тогтоомжийн талаарх асуултууд байна. Гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн шалгалтын сорилын сангийн англи хувилбарын орчуулгыг "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгох журам"-ын 2.2.5-д заасан шаардлагыг хангасан орчуулагчтай нууцлалтай холбоотой гэрээ байгуулж, хийлгэнэ.

3.4.6. Монгол Улсад хоёроос доошгүй жил мэргэжлээрээ тасралтгүй ажилласан бөгөөд зөвшөөрөл үргэлжлүүлэн авах хүсэлт гаргасан гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн шалгалтыг тайлан хамгаалуулах байдлаар зохион байгуулж болно. Тайлан хамгаалалтыг нээлттэй хэлбэрээр тухайн чиглэлийн мэргэжлийн нийгэмлэг, холбоо, мэргэжлийн салбар зөвлөл, эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй тухайн чиглэлийн эмнэлгийн мэргэжилтний оролцоотойгоор зохион байгуулж, дүгнэлт гаргана.

3.5 Эмнэлгийн мэргэжилтэн бүрийн шалгалтын сорил тухайн агшинд санамсаргүй байдлаар сонгогдох байдлаар зөвшөөрлийн шалгалтыг зохион байгуулна.

3.8 Зөвшөөрлийн шалгалтын дүн шалгалт дуусмагц тухайн эмнэлгийн мэргэжилтэнд шууд харагдана. 70 ба түүнээс дээш оноо авсан эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл авах эрх үүснэ.

3.9 Эрүүл мэндийн хөгжлийн төв нь шалгалтын нэгдсэн дүнг шалгалт авсан өдрийн ажлын цагт багтаан Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудаст байршуулна.



3.10 Зөвшөөрлийн шалгалтад тэнцэж, зөвшөөрөл авах эрх үүссэн эмнэлгийн мэргэжилтэн шалгалт өгсөн өдрөөс хойш ажлын 10 хоногийн хугацаанд багтаан тэмдэгтийн хураамж төлж, баталгаажуулна.

3.11 Энэхүү журмын 3.10-т заасан хугацаанд багтаан тэмдэгтийн хураамж төлөөгүй нөхцөлд эмнэлгийн мэргэжилтний тухайн шалгалтын дүнг хүчингүйд тооцно.

### Дөрөв. Багц цаг тооцох

4.1 Зөвшөөрөл бүхий хүний их эмч, уламжлалт анагаах ухааны их эмч, шүдний их эмч, эм зүйч жил тутам 6 багц цаг, эм найруулагч, сувилагч, бага эмч, эх баригч, сэргээн засах чиглэлийн мэргэжилтэн жил тутам 3 багц цаг бүрдүүлж, тооцуулна.

4.2 Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсэгт заасны дагуу багц цагаа бүрдүүлж ажилласан эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар сунгана.

4.3 Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлээрээ ажиллаж байгаа Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын эмч, Хүний гавьяат эмч, Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан, тухайн мэргэжлээрээ 30 ба түүнээс дээш жил ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтний ажиллаж буй эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт, ажлын тайланг үндэслэн зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар сунгана.

4.4 Эмнэлгийн мэргэжилтний жил тутам бүрдүүлэх багц цагийн 2/3-оос доошгүй нь ажиллаж байгаа мэргэжил, мэргэшлийн чиглэлээр, бусад нь ёс зүй, хууль эрх зүй, нийгмийн эрүүл мэнд, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, халдвар хамгааллын чиглэлээр байна.

4.5 Эмнэлгийн мэргэжилтэн бүр эмнэлгийн яаралтай тусламжийн багц цагийн богино хугацааны сургалт (амилуулах суурь тусламж, амилуулах лавшруулсан тусламж, гэмтэгсдийг аврах тусламжийн аль нэг)-д 2 жил тутам, халдвар хамгааллын багц цагийн богино хугацааны сургалтад 3 жил тутам, ёс зүй, хууль эрх зүйн багц цагийн богино хугацааны сургалтад 5 жил тутам суралцаж мэдлэг, ур чадвараа бататгаж, ахиулна.

4.6 Сургалтын 8 цагийн хичээлийг 1 багц цагт тооцно. Нэг цагийн хичээлийн үргэлжлэх хугацаа 45 минут байх ба аудио, видео хичээлийн үргэлжлэх хугацаа 30 минут байна.

4.7 Багц цагийг сургалт болон сургалтын бус хэлбэрээр бүрдүүлж болно. Сургалтыг танхимын болон танхимын бус хэлбэрээр зохион байгуулж болох ба танхимын бус сургалтыг зайны (вэбинар), аудио, видео хичээл хэлбэрээр явуулна. Танхимын бус сургалтаар хангах багц цаг нь тухайн жилд бүрдүүлэх нийт багц цагийн 50 хувиас хэтрэхгүй байна.



4.8 Багц цагийг дараах байдлаар бүрдүүлж, тооцно:

№	Багц цагийг бүрдүүлэх хэлбэр	Тооцох багц цаг	Эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд бүрдүүлэх, баталгаажуулах баримт	
<b>А. Сургалтын хэлбэр</b>				
<b>А-1. Багц цагийн богино хугацааны сургалт</b>				
1.	Тухайн жилд эмнэл зүйн сургагч багшаар ажиллаж, сургалт эрхлэх байгууллагад зохион байгуулагдах мэргэшүүлэх сургалт удирдах	3	Эмнэл зүйн сургагч багшийн гэрчилгээ, мэргэшүүлэх сургалт удирдах тухай сургалт эрхлэх байгууллагын даргын тушаал, тайлан	
2.	Тухайн жилд эмнэл зүйн үндэсний чиглүүлэгч багшаар ажиллаж, эмнэл зүйн сургагч багш бэлтгэх сургалтад 2-оос доошгүй удаа оролцох	Их эмч	6	Эмнэл зүйн чиглүүлэгч багшийн гэрчилгээ, эмнэл зүйн сургагч багш бэлтгэх сургалтын чиглүүлэгч багшаар ажиллуулах тухай Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын тушаал, тайлан
		Сувилагч, эх баригч	3	
3.				
4.	Багц цагийн богино хугацааны сургалт удирдах	4 цаг тутамд 0.5	Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зөвшөөрч, баталсан сургалтын хөтөлбөр, сургалт удирдах тухай сургалт эрхлэх байгууллагын даргын тушаал, тайлан	
5.	Багц цагийн богино хугацааны сургалтад суралцах	Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зөвшөөрсөн багц цаг	Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зөвшөөрч баталсан сургалтын хөтөлбөр, бүртгэл, гэрчилгээ	
<b>А-2. Мэргэжил дээшлүүлэх сургалт</b>				
6.	Мэргэжил дээшлүүлэх сургалтад суралцах	Их эмч, эм зүйч	6	Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зөвшөөрч баталсан сургалтын хөтөлбөр, бүртгэл, гэрчилгээ
		сувилагч, бага эмч, эм найруулагч, эх баригч, сэргээн засах чиглэлийн мэргэжилтэн	3	
<b>А-3. Мэргэшүүлэх сургалт</b>				
7.	Үндсэн мэргэшлийн сургалтад суралцах	Их эмч	Төгссөн жилд-6	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн бүртгэл, Эрүүл мэндийн сайдын тушаалаар олгосон мэргэшлийн үнэмлэх
8.	Төрөлжсөн мэргэшлийн сургалтад суралцах	Их эмч, эм зүйч	Төгссөн жилд-6	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн бүртгэл, Эрүүл мэндийн сайдын тушаалаар олгосон мэргэшлийн үнэмлэх
		сувилагч, эх баригч, хөдөлгөөн засалч	Төгссөн жилд-3	
<b>Б. Сургалтын бус хэлбэр</b>				
1.	Тухайн жилд мэргэшлийн зэрэг	Их эмч, эм зүйч	6	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн бүртгэл, Эрүүл



	хамгаалсан бол	сувилагч, бага эмч, эм найруулагч, эх баригч, сэргээн засах чиглэлийн мэргэжилтэн	3	мэндийн сайдын тушаалаар олгосон мэргэшлийн зэргийн гэрчилгээ
2.	Тухайн жилд боловсролын, эрдмийн зэрэг хамгаалсан бол	анагаах ухаан, эм зүй, сувилахуй, эх барихуйн магистрын зэрэг	3	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн бүртгэл, Шинжлэх ухааны доктор, доктор, магистрын зэргийн диплом
		анагаах ухаан, эм зүй, сувилахуй, эх барихуйн докторын зэрэг	6	
		Анагаахын шинжлэх ухааны докторын зэрэг	6	
		Бусад чиглэлийн магистрын зэрэг	1.5	
		Бусад чиглэлийн докторын зэрэг	3	
3.	Тухайн жилд боловсролын зэргийн ажил удирдаж хамгаалуулсан бол	анагаах ухаан, эм зүй, сувилахуй, эх барихуйн магистрын ажил	1	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн бүртгэл, удирдаж хамгаалуулсаныг нотлох баримт
		анагаах ухаан, эм зүй, сувилахуй, эх барихуйн докторын ажил	2	
4.	Мэргэжлийн чиглэлээр эрдэм шинжилгээний бага хурал, семинар, мэргэжлийн зөвлөгөөнд оролцсон бол	Олон улсын хэмжээнд	2	Хөтөлбөр, гэрчилгээ
		Улсын хэмжээнд	1	
		Орон нутгийн хэмжээнд	0.5	
5.	Мэргэжлийн чиглэлээр эрдэм шинжилгээний бага хурал, семинар, мэргэжлийн зөвлөгөөнд илтгэл тавьсан бол	Олон улсын хэмжээнд	3	Хөтөлбөр, илтгэлийн хураангуй
		Улсын хэмжээнд	2	
		Орон нутгийн хэмжээнд	1	
6.	Мэргэжлийн сэтгүүлд эрдэм шинжилгээний	Олон улсын хэмжээнд	4	Өгүүлэл, шүүмжийн холбогдох линк, хураангуй



	өгүүлэл, шүүмж бичиж хэвлүүлсэн бол	Улсын хэмжээнд	2	
7.	Мэргэжлийн чиглэлээр олон улсын эмнэл зүйн цахим сургалтын платформд хандаж суралцсан бол		Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс дүйцүүлэн тооцсон багц цаг	Сэдэв, гэрчилгээ
8.	Мэргэжлийн сурах бичиг, нэг сэдэвт бүтээл, гарын авлага нийтлүүлсэн бол	Зохиож нийтлүүлсэн бол	3	Хэвлүүлсэн бүтээл
		Хамтран зохиож нийтлүүлсэн бол	1	
9.	Мэргэжлийн чиглэлээр эрүүл мэндийн салбарын олон улсын болон улсын хэмжээний уралдаан, тэмцээн, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан, удирдсан, шүүгчээр ажилласан бол		1	Тайлан
10.	Эрүүл мэндийн салбарын төсөл, судалгаанд оролцсон бөгөөд судалгааны ажил, тайлан хэвлэгдсэн бол		1	Хэвлүүлсэн судалгаа
11.	Оношилгоо, эмчилгээ, сувилгааны стандарт, заавар боловсруулахад оролцсон бөгөөд стандарт, заавар батлагдсан бол		1	Батлагдсан стандарт, заавар
12.	Эмчилгээ, оношилгооны шинэ арга боловсруулах, инноваци, шинэ технологи гаргаж, нэвтрүүлэх		2	Тухайн хүний нэр бүхий эмчилгээ, оношилгооны шинэ арга, инноваци, шинэ технологийн бүтээлийн хуулбар (мэдээний сангийн бүртгэлд давхцаагүй байх)
13.	Мэргэжлийн нийгэмлэг, холбооноос зохион байгуулсан эрүүл мэндийн сайн дурын үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон бол		1 багц цаг хүртэл	Мэргэжлийн нийгэмлэг, холбооны тодорхойлолт
14.	Резидент эмч, төрөлжсөн мэргэшлийн сургалтад суралцагч эмчийн хувьд сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан эрүүл мэндийн сайн дурын ажилд идэвхтэй оролцсон бол		1 багц цаг хүртэл	Сургалт эрхлэх байгууллагын бүртгэл

4.9 Эмнэлгийн мэргэжилтний тухайн жилд бүрдүүлсэн багц цаг нь энэхүү журмын 4.1-т зааснаас илүү гарсан тохиолдолд дараагийн жилд шилжүүлэн тооцохгүй.

4.10 Эмнэлгийн мэргэжилтэн гадаад улсад өөрийн мэргэжил, мэргэшлийн чиглэлээр төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон тасралтгүй сургалтад суралцсан, магистр, докторын сургалтад хамрагдсан тохиолдолд багц цагийг дотоодын сургалттай адилтган үзэж, гэрчилгээ, үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичгийг үндэслэн тооцно.



4.11 Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс олгосон төгсөлтийн дараах сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагаас зохион байгуулсан сургалтын багц цагийг хүчинтэйд тооцно.

4.12 Багц цаг бүрдүүлсэн эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрөл нь зөвшөөрлийн гэрчилгээнд заасан хугацаанд хүчинтэйд тооцогдоно.

4.13 Багц цаг бүрдүүлээгүй эмнэлгийн мэргэжилтэн зөвшөөрлийн шалгалт өгнө.

4.14 Эмнэлгийн мэргэжилтэн дор дурдсан үндэслэлийг албан ёсны бичиг баримтаар нотолсон тохиолдолд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлсэн хугацаанд оруулан тооцож, тухайн хугацаанд багц цаг бүрдүүлэхээс чөлөөлнө:

4.14.1 жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй;

4.14.2 цэргийн жинхэнэ алба хаасан, энхийг сахиулах ажиллагаанд оролцсон;

4.14.3 өөрийн болон гэр бүлийн гишүүний биеийн эрүүл мэндийн байдлын улмаас мэргэжлээрээ ажиллахгүйгээр эмчлүүлж, сувилуулсан;

4.14.4 донорын үүрэг гүйцэтгэсэн.

#### **Тав. Зөвшөөрлийн гэрчилгээ олгох, нөхөн олгох**

5.1 Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэгт заасанчлан эмнэлгийн мэргэжилтэнд 3 ба 5 жилийн хугацаагаар зөвшөөрөл олгоно.

5.2 Зөвшөөрөл олгосныг нотлох баримт нь зөвшөөрлийн гэрчилгээ байна. Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.17 дахь хэсэгт заасны дагуу эмнэлгийн мэргэжилтэн бүр зөвшөөрлийн давтагдашгүй дугаар бүхий зөвшөөрлийн гэрчилгээтэй байх ба давтагдашгүй дугаар нь боловсролын стандартын ангилал, индексийг багтаасан 8 орон тоо бүхий тэмдэгт байна.

5.3 Эрүүл мэндийн хөгжлийн төв нь зөвшөөрөлтэй холбоотой шийдвэрийн төслийг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр хүргүүлэх ба шийдвэрийн төслийн үнэн зөв байдлыг бүрэн хариуцна.

5.4 Энэхүү журмын 5.3-т заасан шийдвэрийн төслийг үндэслэн Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3, 25.5-25.7-д заасны дагуу эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгоно.

5.5 Энэхүү журмын 5.4-т заасан шийдвэр батлагдсанаас хойш ажлын 10 хоногт багтаан энэхүү тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан загварын дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын гарын үсэг, тамга бүхий зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгоно.

5.6 Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын эсхүл эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтанд эсхүл эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрлийн гэрчилгээг албан ёсоор хүлээлгэн өгч, энэ тухай тэмдэглэл үйлдэж баримтжуулна.



5.7 Зөвшөөрлийн гэрчилгээг нөхөн авах хүсэлтэй эмнэлгийн мэргэжилтэн эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд цахимаар хүсэлт гаргана. Эрүүл мэндийн хөгжлийн төв нь зөвшөөрлийн гэрчилгээг нөхөн олгох үндэслэлтэй (зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дуусаагүй, багц цаг бүрдүүлсэн) гэж үзвэл зөвшөөрлийн гэрчилгээг үрэгдүүлсэн тухай Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудсаар нийтэд зарлана.

5.8 Зөвшөөрлийн гэрчилгээг тухайн зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд зөвхөн нэг удаа нөхөн олгох бөгөөд шинээр олгох зөвшөөрлийн гэрчилгээн дээр "нөхөн олгов" гэж тэмдэглэнэ.

5.9 Эмнэлгийн мэргэжилтний үндсэн, төрөлжсөн мэргэшлээр ажиллах баталгаа нь тухайн мэргэшлийн сургалтад суралцсаныг нотлох мэргэшлийн үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичиг байна.

5.10 Зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу түтгэлзүүлж, сэргээж, хүчингүй болгоно.

### Зургаа. Бусад

6.1 Эрүүл мэндийн хөгжлийн төв нь зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ улирал тутам хийж, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлнэ.

6.2 Эрүүл мэндийн хөгжлийн төвийн зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

6.3 Энэхүү журмын 6.2-т заасан хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, санал, зөвлөмжийг Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн хурлаар тухай бүр хэлэлцүүлж, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна.

6.4 Энэхүү журмыг зөрчсөн эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллагын холбогдох албан тушаалтанд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.



Эрүүл мэндийн сайдын 2023 оны  
08 дугаар сарын 14-ны өдрийн  
1/295 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



## ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭНД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилго нь төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эмчилгээ оношилгооны технологи, инноваци шинээр нэвтрүүлэхтэй холбогдуулан гадаадын эмнэлгийн мэргэжилтэнг Монгол Улсад урьж ажиллуулахад үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (цаашид "зөвшөөрөл" гэх) олгох үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль, энэхүү журам болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

1.3 Энэхүү журмаар зөвшөөрөлтэй холбоотой дараах харилцааг зохицуулна:

1.3.1 эрүүл мэндийн байгууллага, гадаадын эмнэлгийн мэргэжилтний эрх, үүрэг

1.3.2 зөвшөөрөл олгоход баримтлах зарчим, шалгуур;

1.3.1. зөвшөөрөл анх удаа болон дахин олгох.

1.4 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэн нь Монгол Улсад үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл авчран, үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд холбогдох хууль, журамд заасны дагуу эмийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна.

1.5 "Зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах, багц цаг тооцох, зөвшөөрлийн гэрчилгээ олгох, нөхөн олгох журам"-ын 1.4-1.8, 2, 3, 6 дугаар бүлэг, 5.2, 5.8 дахь заалт энэхүү журамд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

1.6 Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр зөвшөөрөл олгосон гадаадын эмнэлгийн мэргэжилтний Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас шийдвэрлэж олгоно.





**Хоёр. Эрүүл мэндийн байгууллага, гадаадын эмнэлгийн мэргэжилтний эрх, үүрэг**

**2.1 Эрүүл мэндийн байгууллага нь дараах эрхтэй:**

- 2.1.1 гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн асуудлаар хүсэлт гаргаж, Зөвшөөрлийн тухай хууль, энэхүү журамд заасан хугацаанд шийдвэрлүүлэх;
- 2.1.2 гадаадын эмнэлгийн мэргэжилтний цалин хөлсийг хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох, олгох;
- 2.1.3 гадаадын эмнэлгийн мэргэжилтэн гэрээний заалт биелүүлээгүй тохиолдолд гэрээг хугацаанаас өмнө цуцлах.

**2.2 Эрүүл мэндийн байгууллага нь дараах үүрэгтэй:**

- 2.2.1 өөрийн үйл ажиллагааны чиглэлд нийцэх төрөлжсөн мэргэшил эзэмшсэн гадаадын эмнэлгийн мэргэжилтнийг урьж ажиллуулах, баримт бичгийг үнэн зөв бүрдүүлэх, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах;
- 2.2.2 гадаад улс дахь эрүүл мэндийн байгууллагатай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хүрээнд энэхүү журмын 1.1, 3.1-т заасныг баримтлан гадаадын эмнэлгийн мэргэжилтэн урьж ажиллуулах;
- 2.2.3 гадаадын эмнэлгийн мэргэжилтэнтэй байгуулах гэрээнд албан тушаал, хөдөлмөрийн нөхцөл, хугацаа, үзүүлэх тусламж, үйлчилгээний төрөл, тоо хэмжээ, тусламж, үйлчилгээ үзүүлэх байр, орчин, цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, татварын зохицуулалт, тухайн гадаадын эмнэлгийн мэргэжилтэн нутаг буцсан тохиолдолд тусламж, үйлчилгээ үзүүлсэн өвчтөнг хариуцаж ажиллах эмнэлгийн мэргэжилтний үүрэг оролцоо, эмнэлгийн мэргэжилтний болон био-анагаахын ёс зүйн хэм хэмжээ зөрчигдсэн, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан болон бусад зөрчил, сөрөг үр дагавар гарсан тохиолдолд хүлээх хариуцлагын талаар тусгаж, мөрдөж ажиллах;
- 2.2.4 энэхүү журмын 4.1, 5.1-т заасан хугацаанд багтаан гадаадын эмнэлгийн мэргэжилтэн ажиллуулах хүсэлт, холбогдох баримт бичгийг Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлэх, журамд заасан хугацаанд хүсэлт ирүүлээгүй, нэмэлтээр шаардсан хууль ёсны мэдээллийг гаргаж ирүүлээгүйн улмаас зөвшөөрөл олгогдоогүй тохиолдолд тухайн гадаадын эмнэлгийн мэргэжилтэнг ажиллуулахгүй байх;
- 2.2.5 Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10 дахь хэсэгт заасны дагуу гадаадын эмнэлгийн мэргэжилтэн эмнэлгийн тусламж үйлчилгээг монгол хэлээр үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх, тухайн гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх гадаад хэлийг ахисан дунд, дээд түвшинд

эзэмшсэн, эрүүл мэндийн чиглэлээрх орчуулгын туршлагатай орчуулагч ажиллуулах;

2.2.6 гадаадын эмнэлгийн мэргэжилтэн үргэлжлүүлэн ажиллах, дахин ирж ажиллах тохиолдолд тухайн мэргэжилтний ажлын тайланг биечлэн гаргуулж, гарын үсэг зурж баталгаажуулах, тайланг монгол хэл рүү хөрвүүлж, бичиг баримтад хавсаргах;

2.2.7 гадаадын эмнэлгийн мэргэжилтэнтэй байгуулсан гэрээг цуцалсан эсхүл үргэлжлүүлэн ажиллахгүй тохиолдолд Эрүүл мэндийн хөгжлийн төв, гадаадын иргэний болон хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ажлын 5 хоногт багтаан мэдэгдэх;

2.2.8 гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан болон бусад зөрчил, сөрөг үр дагавар гарсан тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээж, үйлчлүүлэгчид учирсан хохирлыг барагдуулах.

2.3 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэн дараах эрхтэй:

2.3.1 энэхүү журмын 2.2.3-т заасан гэрээ байгуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээг монгол хэлээр үзүүлэх нөхцлөөр хангуулах, журмын 2.2.5-д заасан шалгуур хангасан орчуулагчтай ажиллах;

2.3.2 "Гүйцэтгэх ажил үйлчилгээний төлөвлөгөө"-г эрүүл мэндийн байгууллагатай хамтран боловсруулж, баталгаажуулах;

2.3.3 эрүүл мэндийн байгууллага гэрээний заалт биелүүлээгүй тохиолдолд гэрээг хугацаанаас өмнө цуцлах.


2.4 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэн дараах үүрэгтэй:

2.4.1 өөрийн холбогдох мэдээлэл, баримт бичгийг албан ёсны англи орчуулгын хамт бүрдүүлж, үнэн зөв мэдүүлэх, эрх бүхий байгууллагаас нэмэлтээр шаардсан хууль ёсны мэдээллийг шуурхай гаргаж өгөх;

2.4.2 Монгол Улсад ажиллах хугацаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг бүрэн сахиж, эмнэлгийн мэргэжилтний, био-анагаахын ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллах;

2.4.3 эзэмшсэн төрөлжсөн мэргэшлийн чиглэлийн дагуу олгосон зөвшөөрлийн төрөл, хугацааны хүрээнд зөвхөн гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллагад ажиллах;

2.4.4 Монгол Улсын эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй заавар, стандартад нийцүүлэн эмнэлгийн тусламж, үйлчилгээг мэргэжлийн түвшинд чанартай үзүүлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ холбогдох дүрэм, журамд заасны дагуу үйлчлүүлэгчийн зөвшөөрлийг бичгээр авах;



- 2.4.5 зөвшөөрлийн хугацаа дуусгавар болж, нутаг буцахдаа энэхүү журмын 2.2.3-т заасны дагуу тусламж, үйлчилгээ үзүүлсэн өвчтөнг монгол талын эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн мэргэжилтэнд хариуцуулж, хүлээлгэн өгөх;
- 2.4.6 Монгол Улсад хоёроос доошгүй жил төрөлжсөн мэргэшлээр тасралтгүй ажилласан бөгөөд цаашид зөвшөөрөл үргэлжлүүлэн авах хүсэлт гаргах нөхцөлд Монгол хэлний түвшин тогтоох стандарт шалгалт (TOMFL-Test of Mongolian as a Foreign Language) өгч, дунд эсхүл ахисан түвшинтэй гэж тодорхойлогдсон байх;
- 2.4.7 Гэрээ байгуулан ажиллаж буй эрүүл мэндийн байгууллагын болон эрүүл мэндийн салбарын монгол эмнэлгийн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, мэдлэг, ур чадвараа сайжруулахад нь дэмжлэг үзүүлэх (оношилгоо, эмчилгээг хамтран хийх, сургалт, семинар, конференц хамтран зохион байгуулах эсхүл оролцох);
- 2.4.8 үргэлжлүүлэн ажиллах, дахин ирж ажиллах хүсэлт гаргах тохиолдолд ажлын тайлангаа биечлэн гаргаж, гарын үсэг зурж баталгаажуулах;
- 2.4.9 мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан болон бусад зөрчил, сөрөг үр дагавар гарсан тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээж, үйлчлүүлэгчид учирсан хохирлыг барагдуулах.

#### **Гурав. Зөвшөөрөл олгоход баримтлах зарчим, шалгуур**

3.1 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгоход "Зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах, багц цаг тооцох, зөвшөөрлийн гэрчилгээ олгох, нөхөн олгох журам"-ын 1.4-т зааснаас гадна дараах зарчмыг баримтална:

- 3.1.1 Монгол Улсын эмнэлгийн тусламж, үйлчилгээний тэргүүлэх чиглэлтэй нийцүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шинэ технологи, инноваци нэвтрүүлж, нутагшуулах;
- 3.1.2 Монгол Улсад тухайн төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэгдээгүй эсхүл дутагдалтай тохиолдолд гадаадын эмнэлгийн мэргэжилтэн ажиллуулах;
- 3.1.3 Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, гадаадын эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн үйл ажиллагааг бие даан монгол хэл дээр явуулахад анхаарч, дэмжих;
- 3.1.4 гадаад улсад оношилгоо, эмчилгээ хийлгэх иргэдийн урсгалыг бууруулах.

3.2 Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэгт заасан шалгуурыг хангасан гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгох ба гадаадын эмнэлгийн мэргэжилтэн нь олгосон зөвшөөрлийн төрлөөр төрөлжсөн мэргэшлийн үйл ажиллагаа эрхэлнэ.



3.3 Монгол Улсад эмнэлзүйн заавар, стандарт нь батлагдсан төрөлжсөн мэргэшлийн чиглэл болон өндөр хөгжилтэй орны анагаах ухааны салбарт нэвтэрч, үр дүн нь нотлогдсон эмчилгээ, оношилгоо, сувилахуй, сэргээн засахын чиглэлээр гадаадын эмнэлгийн мэргэжилтэн ажиллуулна.

3.4 Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх гадаадын эмнэлгийн мэргэжилтний насны хязгаарыг тодорхойлохдоо Төрийн албаны тухай хуулийн Арван нэгдүгээр бүлгийн 41 дүгээр зүйл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн Хоёрдугаар бүлгийн 4 дүгээр зүйлд заасныг баримтална.

3.5 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгоход холбогдох хууль тогтоомжид заасан насны хязгаарыг дараах тохиолдолд баримтлахгүй байж болно:

3.5.1 ашгийн бус зорилгоор эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх олон улсад нэр хүндтэй эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын багийн гишүүнээр ажилладаг.

3.6 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд дараах тохиолдолд зөвшөөрөл олгох шаардлагагүй бөгөөд холбогдох хууль тогтоомжид заасан насны хязгаар хамаарахгүй:

3.6.1 эмнэл зүйн конференц зохион байгуулах, оролцох;

3.6.2 эмнэл зүйн сургалт (үйлчлүүлэгч, өвчтөнтэй шууд харилцахгүй симуляцид суурилсан сургалт, танхимын сургалт, семинар) зохион байгуулах, оролцох.

#### **Дөрөв. Зөвшөөрөл анх удаа олгох**

4.1 Монгол талын эрүүл мэндийн байгууллага нь гадаадын эмнэлгийн мэргэжилтэн Монгол Улсад ирэхээс ажлын 40-өөс доошгүй хоногийн өмнө энэхүү тушаалын гуравдугаар хавсралтад заасан баримт бичгийг цахим хэлбэрээр бүрдүүлж, Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлнэ.

4.2 Эрүүл мэндийн хөгжлийн төв нь энэхүү журмын 4.1-д заасан баримт бичгийг хүлээн авч, магадлан шалгах бөгөөд тухайн гадаадын мэргэжилтний ажиллах чиглэл нь энэхүү журмын 3.1.1-3.1.4-т заасан зарчим, 3.3-т заасантай нийцэх эсэх санал, дүгнэлт ирүүлэх хүсэлтийг тухайн чиглэлийн мэргэжлийн нийгэмлэг, холбоо, мэргэжлийн салбар зөвлөлд хүргүүлнэ.

4.3 Мэргэжлийн нийгэмлэг, холбоо, мэргэжлийн салбар зөвлөл нь гадаадын эмнэлгийн мэргэжилтний талаарх санал, дүгнэлт, зөвлөмжийг Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлнэ.

4.4 Эрүүл мэндийн хөгжлийн төв нь шалгуур хангасан гадаадын эмнэлгийн мэргэжилтний баримт бичгийн эх хувь, танилцуулга, энэхүү журмын 4.3-т заасан санал, дүгнэлт, зөвлөмжийг нэгтгэж, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн хурлаар тухайн гадаадын эмнэлгийн мэргэжилтэн Монгол Улсад ирэхээс 7-оос доошгүй ажлын хоногийн өмнө хэлэлцүүлнэ.



4.5 Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөл нь энэхүү журмын 3 дугаар бүлэгт заасныг баримтлан гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгох эсэх талаар шийдвэр гаргана.

4.6 Энэхүү журмын 4.5-д заасан шийдвэрийг үндэслэн гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгох шийдвэрийн төслийг Эрүүл мэндийн хөгжлийн төв боловсруулж эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.7 Энэхүү журмын 4.5, 4.6-д заасан шийдвэр, шийдвэрийн төслийг үндэслэн Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.9.1-т заасны дагуу эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр 6 сар хүртэлх хугацаатай зөвшөөрөл олгоно.

4.8 Энэхүү журмын 4.7-д заасан шийдвэр батлагдсанаас хойш ажлын 2 хоногт багтаан энэхүү тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан загварын дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын гарын үсэг, тамга бүхий зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгоно.

4.9 Гадаадын эмнэлгийн мэргэжилтний баримт бичиг шалгуур хангаагүй тохиолдолд Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс шалтгааныг дурдсан мэдэгдлийг эрүүл мэндийн байгууллагад хүргүүлнэ.

#### **Тав. Зөвшөөрөл дахин олгох**

5.1 Энэхүү журмын 4.7-д заасан шийдвэрээр 6 сар хүртэлх хугацаагаар анх удаа зөвшөөрөл олгосон гадаадын эмнэлгийн мэргэжилтэнг Монгол Улсад үргэлжлүүлэн ажиллуулах тохиолдолд монгол талын эрүүл мэндийн байгууллага нь зөвшөөрлийн хугацаа дуусахаас ажлын 30-аас доошгүй хоногийн өмнө энэхүү тушаалын гуравдугаар хавсралтад заасан баримт бичгийг цахим хэлбэрээр бүрдүүлж, Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлнэ.


5.2 Эрүүл мэндийн хөгжлийн төв энэхүү журмын 5.1-т заасан баримт бичгийг магадлан шалгаж, тухайн эрүүл мэндийн байгууллагад хариу мэдэгдэнэ:

5.2.1 баримт бичиг шалгуур хангасан тохиолдолд тухайн гадаадын эмнэлгийн мэргэжилтэн зөвшөөрлийн шалгалтад орох тухай;

5.2.2 баримт бичиг шалгуур хангаагүй тохиолдолд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл үргэлжлүүлэн олгох боломжгүй тухай мэдэгдэл хүргүүлнэ.

5.3 Эрүүл мэндийн хөгжлийн төв зөвшөөрлийн шалгалтын бэлтгэлийг хангаж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын баталсан зааврын дагуу "Зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах, багц цаг тооцох, зөвшөөрлийн гэрчилгээ олгох, нөхөн олгох журам"-ын 3 дугаар бүлэгт заасны дагуу сорилын шалгалт эсхүл тайлан хамгаалалт хэлбэрээр зохион байгуулна.

5.4 Энэхүү журмын 5.3-т заасан зааварт сорилын нууцлал, сорил сонгох явц, гадаадын эмнэлгийн мэргэжилтэн бие даан эсхүл орчуулагчийн тусламжтайгаар



зөвшөөрлийн шалгалт өгөх хугацааны хязгаар, сорил, тайлан хамгаалалтын агуулгыг тусгана.

5.5 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэн нь зөвшөөрлийн шалгалтыг монгол, англи хэлний аль нэгийг сонгож өгнө. Шаардлагатай тохиолдолд Эрүүл мэндийн хөгжлийн төвд тайлбар гаргасны үндсэн дээр энэхүү журмын 2.2.3-т заасан шалгуур хангасан албан ёсны орчуулагчийн тусламж авч болно.

5.6 Монгол Улсад хоёроос доошгүй жил мэргэжлээрээ тасралтгүй ажилласан бөгөөд зөвшөөрөл үргэлжлүүлэн авах хүсэлт гаргасан гадаадын эмнэлгийн мэргэжилтэн нь зөвшөөрлийн шалгалтыг монгол хэлээр өгнө.

5.7 Зөвшөөрлийн шалгалтад тэнцсэн гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгох шийдвэрийн төслийг Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.8 Энэхүү журмын 5.7-д заасан шийдвэрийн төслийг үндэслэн Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.9.2-т заасны дагуу 2 жил хүртэл хугацаагаар мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр олгоно. Энэ тохиолдолд уг асуудлыг Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх шаардлагагүй.

5.9 Энэхүү журмын 5.8-д заасан шийдвэр батлагдсанаас хойш ажлын 2 хоногт багтаан энэхүү тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан загварын дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын гарын үсэг, тамга бүхий зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгоно.

5.10 Дараах тохиолдолд гадаадын эмнэлгийн мэргэжилтнээс зөвшөөрлийн шалгалт авахгүй, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхгүй бөгөөд Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс ирүүлсэн шийдвэрийн төслийг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлийн асуудал хариуцсан нэгж хянаж, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга зөвшөөрсөнөөр эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийг батлуулна:

5.10.1 Монгол Улсад тохиолдсон байгалийн гамшиг, осол, нийтийг хамарсан аюул бүхий халдварт өвчний дэгдэлт болон бусад онцгой тохиолдлын үед Монгол Улсын Засгийн газрын хүсэлтээр 30 хоног хүртэлх хугацаагаар анх удаа болон дахин ирж ажиллах гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд ажлын 1 хоногт багтаан;

5.10.2 Засгийн газрын гэрээ, хэлэлцээрийн дагуу төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг иргэдэд үнэ төлбөргүй үзүүлэх зорилгоор 30 хоног хүртэлх хугацаагаар анх удаа болон дахин ирж ажиллах гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд ажлын 5 хоногт багтаан;

5.10.3 өмчийн хэлбэр харгалзахгүйгээр төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, тусгай эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, сэргээн засахын төв, амаржих газар болон тухайн гадаадын эмнэлгийн мэргэжилтний харьяалах үндсэн эрүүл мэндийн байгууллага хооронд байгуулсан 3-аас доошгүй жилийн хугацаатай "Хамтын" ажиллагааны



гэрээ"-ний дагуу өмнөх 1-3 жилийн хугацаанд ирж ажиллахдаа Зөвшөөрлийн тухай хуулийн Зургадугаар бүлгийн 6.2 дугаар зүйлийн 1.2-1.9 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.21.1-25.21.3 дахь заалтад заасан зөрчил гаргаагүй гадаадын эмнэлгийн мэргэжилтэн дахин ирж ажиллах тохиолдолд 30 хоног хүртэлх хугацаатай зөвшөөрлийг ажлын 10 хоногт багтаан.

5.11 Энэхүү журмын 4.7, 5.7, 5.9-д заасан шийдвэрийн төслийн үнэн зөв байдлыг Эрүүл мэндийн хөгжлийн төв бүрэн хариуцна.

5.12 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд олгосон зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу түтгэлзүүлж, сэргээж, хүчингүй болгоно.

5.13 Энэхүү журмыг зөрчсөн эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллагын холбогдох албан тушаалтанд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.




### ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭХЭД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

1. Зөвшөөрлийн шалгалт өгөх, багц цаг тооцуулахад бүрдүүлэх баримт бичиг

№	Бүрдүүлэх баримт бичиг	Зөвшөөрлийн шалгалт өгөх	Багц цаг бүрдүүлж, тооцох
1.	Эмнэлгийн мэргэжилтний бүртгэлийн нэгдсэн санд цахимаар гаргасан хүсэлт	+	+
2.	"Зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах, багц цаг тооцох, зөвшөөрлийн гэрчилгээ олгох, нөхөн олгох журам"-ын 4.8-д заасан бичиг баримт		+
3.	Шалгалтын хураамж төлсөн баримт	+	
4.	Тэмдэгтийн хураамж төлсөн баримт /багц цаг бүрэн бүрдүүлж эсхүл зөвшөөрлийн шалгалтад тэнцэж, зөвшөөрлийн гэрчилгээ авахад/	+	+

2. Гадаадын эмнэлгийн мэргэжилтэн Монгол Улсад зөвшөөрөл хүсэхэд бүрдүүлэх баримт бичиг

№	Бүрдүүлэх баримт бичиг	Зөвшөөрөл хүсэх	
		Анх удаа	Дахин
1.	Эмнэлгийн мэргэжилтний бүртгэлийн нэгдсэн санд цахимаар гаргасан хүсэлт	+	+
2.	Тухайн төрөлжсөн мэргэшлээр гадаадын эмнэлгийн мэргэжилтэн зайлшгүй ажиллуулах үндэслэл (Монгол Улсад тухайн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэгдээгүй эсхүл дутагдалтай, эмчилгээ, оношилгоо шинэ технологи нэвтрүүлэх, Монгол Улсын эмнэлгийн мэргэжилтнийг дагалдуулан сургах, Монгол Улсад гадаадын эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход баримтлах эмнэлгийн тусламж, үйлчилгээний тэргүүлэх чиглэлд нийцэж байгаа гэх мэт)-ийг тодорхойлсон албан бичиг	+	
3.	Эрүүл мэндийн байгууллагын даргын баталсан гадаадын эмнэлгийн мэргэжилтний Монгол Улсад ажиллах хугацаанд гүйцэтгэх ажил үйлчилгээний төрөл, давтамж, тоо хэмжээ, үйлчилгээний төлбөр, монгол талын эрүүл мэндийн байгууллагын хамтран ажиллах эмнэлгийн мэргэжилтэн, гадаадын эмнэлгийн мэргэжилтэн нутаг буцсаны дараа тусламж, үйлчилгээ үзүүлсэн өвчтөнг хариуцаж ажиллах эмнэлгийн мэргэжилтний үүрэг оролцоог тусгасан "Гүйцэтгэх ажил үйлчилгээний төлөвлөгөө"	+	
4.	Гадаадын эмнэлгийн мэргэжилтний танилцуулга (5 дугаар хавсралтын дагуу)	+	+





5.	Гадаадын эмнэлгийн мэргэжилтний хүчин төгөлдөр паспорт, түүнийг орлох хууль ёсны баримт бичиг	+	+ (шинээр олгосон, сунгалт хийгдсэн бол)
6.	Гадаадын эмнэлгийн мэргэжилтний хүчин төгөлдөр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл буюу түүнтэй адилтгах хүчин төгөлдөр баримт бичиг, баталгаат монгол орчуулгын хамт	+	+ (сунгалт хийгдсэн бол)
7.	Анагаах ухааны чиглэлээр боловсрол эзэмшсэнийг нотлох үнэмлэх, диплом, түүнтэй адилтгах хүчин төгөлдөр баримт бичиг, баталгаат монгол орчуулгын хамт	+	
8.	Төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр суралцсаныг нотлох хүчин төгөлдөр баримт бичиг, баталгаат монгол орчуулгын хамт	+	
9.	Гадаадын эмнэлгийн мэргэжилтний үндсэн эрүүл мэндийн байгууллага, Монгол талын эрүүл мэндийн байгууллага хооронд байгуулсан хүчин төгөлдөр гэрээ, баталгаат монгол орчуулгын хамт	+	+ (сунгалт хийгдсэн бол)
10.	Энэхүү журмын 6.4-т заасан шалгуурыг хангасныг нотлох орчуулагчийн баримт бичгийн баталгаат хуулбар	+	+ (орчуулагч өөрчлөгдсөн бол)
11.	Тухайн төрөлжсөн мэргэшлээр гадаадын эмнэлгийн мэргэжилтэн зайлшгүй үргэлжлүүлэн ажиллуулах үндэслэл, албан бичгийн хамт		+
12.	Гадаадын эмнэлгийн мэргэжилтний биечлэн гаргаж, гарын үсэг зурж баталгаажуулсан ажлын тайлан, баталгаат монгол орчуулгын хамт		+
13.	Шалгалтын хураамж төлсөн баримт /зөвшөөрөл дахин авах хүсэлт гаргахад/		+
14.	Тэмдэгтийн хураамж төлсөн баримт / багц цаг бүрэн бүрдүүлж эсхүл зөвшөөрлийн шалгалтад тэнцэж зөвшөөрлийн гэрчилгээ авахад/	+	+
15.	Монгол хэлний түвшин тогтоох стандарт шалгалт (TOMFL-Test of Mongolian as a Foreign Language)-аар дунд эсхүл ахисан түвшинтэй байх (Монгол Улсад хоёроос доошгүй жил төрөлжсөн мэргэшлээрээ тасралтгүй ажилласан бөгөөд цаашид зөвшөөрөл үргэлжлүүлэх авах хүсэлт гаргахад шаардлагатай)		+
16.	Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хуулбар		+
17.	Монгол Улсад оршин суух үнэмлэхийн хуулбар		+

Тайлбар: Бүрдүүлэх шаардлагатай бичиг баримтыг + гэж тэмдэглэв.



А/295 08  
Эрүүл мэндийн сайдын 2023 оны  
дугаар сарын 14-ны өдрийн  
дугаар тушаалын 4 дүгээр хавсралт

**ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР**

1. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.1-д заасан хугацаагаар резидент эмчид олгох "Эмчлэх" үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичвэртэй байна:

- Гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Гэрчилгээ нь хөх цэнхэр дэвсгэртэй, цайвар цагаан алхан хээн хүрээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж "Монгол Улс", "Эрүүл мэндийн яам", "Эрүүл мэндийн хөгжлийн төв", түүний доод хэсэгт "Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ГЭРЧИЛГЭЭ" гэж бичсэн байна.
- Гэрчилгээний баруун доод буланд QR код байна.
- QR кодны доор "QR кодоор <http://hr.hdc.gov.mn/> цахим хуудаст хандаж, эмнэлгийн мэргэжилтний мэдээлэлтэй танилцах боломжтой" гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.

**МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ**

..... оны ..... сарын .....-ны өдөр .....улсын  
.....хот/аймаг/мужид төрсөн  
..... Улсын иргэн

**РЕЗИДЕНТ ЭМЧ**

..... /Ургийн овог/ ..... /эцэг/эхийн нэр/...../өөрийн нэр/-д

Эрүүл мэндийн сайдын ..... оны ..... сарын ..... өдрийн ..... дугаар тушаалаар ЭМЧЛЭХ үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл ..... оны .....сарын .....-ны өдрөөс ..... оны ..... сарын .....-ны өдөр хүртэл ..... жилийн хугацаатай олгов.

Энэхүү зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд ..... төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх байгууллагад ..... үндсэн мэргэшлийн чиглэл, индексээр ..... жилийн хугацаагаар ажиллан суралцахыг ..... зөвшөөрлийн дахин давтагдашгүй дугаараар ..... оны .... сарын .....-ны өдөр ..... Эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд бүртгэв.

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ.....**

Огноо: ..... он ..... сар ..... өдөр

- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл олгосон тухайн эмнэлгийн мэргэжилтний 3х4 см зураг байрлуулна.
- Гэрчилгээг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын гарын үсэг, тамгаар албажуулна.



2. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.2-д заасан хугацаагаар үндсэн мэргэшлийн мэргэшсэн эмчид олгох "Эмчлэх" үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичвэртэй байна

- Гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Гэрчилгээ нь цайвар ногоон дэвсгэртэй, тод ногоон угалзан хээн хүрээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж "Монгол Улс", "Эрүүл мэндийн яам", "Эрүүл мэндийн хөгжлийн төв", түүний доод хэсэгт "Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ГЭРЧИЛГЭЭ" гэж бичсэн байна.
- Гэрчилгээний баруун доод буланд QR код байна.
- QR кодны доор "QR кодоор <http://hr.hdc.gov.mn/> цахим хуудаст хандаж, эмнэлгийн мэргэжилтний мэдээлэлтэй танилцах боломжтой" гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.

### МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

..... оны ..... сарын .....-ны өдөр .....улсын  
.....хот/аймаг/мужид төрсөн

..... Улсын иргэн

### МЭРГЭШСЭН ШҮДНИЙ ИХ ЭМЧ, МЭРГЭШСЭН ХҮНИЙ ИХ ЭМЧ, МЭРГЭШСЭН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ЭМЧ (аль нэгийг бичих)

..... /Ургийн овог/ ..... /эцэг/эхийн нэр/...../өөрийн  
нэр/-д

Эрүүл мэндийн сайдын ..... оны ..... сарын ..... өдрийн  
..... дугаар тушаалаар ЭМЧЛЭХ үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл ..... оны  
.....сарын .....-ны өдрөөс ..... оны ..... сарын .....-ны өдөр хүртэл ..... жилийн  
хугацаатай олгов.

Энэхүү зөвшөөрлийг .... оны .... сарын .....-ны өдөр ..... зөвшөөрлийн  
дахин давтагдашгүй дугаараар Эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд  
бүртгэв.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ.....

Огноо: ..... он ..... сар ..... өдөр

- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл олгосон тухайн эмнэлгийн мэргэжилтний 3х4 см зураг байрлуулна.
- Гэрчилгээг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын гарын үсэг, тамгаар албажуулна.



3. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.1-т заасан хугацаагаар анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургуулийг шинээр төгссөн их эмчид олгох "Эмчлэх" үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ, Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.2-т заасан хугацаагаар үндсэн мэргэшлийн сургалтад суралцахгүйгээр тухайн эзэмшсэн ерөнхий мэргэжлээр үргэлжлүүлэн ажиллах их эмчид олгох "Эмчлэх" үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичвэртэй байна:

- Гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Гэрчилгээ нь шинэ төгсөгчийн хувьд цайвар шар дэвсгэртэй, цайвар угалзан хээн хүрээтэй, ерөнхий мэргэжлээр үргэлжлүүлэн ажиллах их эмчийн хувьд цайвар ногоон дэвсгэртэй, цайвар цагаан угалзан хээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж "Монгол Улс", "Эрүүл мэндийн яам", "Эрүүл мэндийн хөгжлийн төв", түүний доод хэсэгт "Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ГЭРЧИЛГЭЭ" гэж бичсэн байна.
- Гэрчилгээний баруун доод буланд QR код байна.
- QR кодны доор "QR кодоор <http://hr.hdc.gov.mn/> цахим хуудаст хандаж, эмнэлгийн мэргэжилтний мэдээлэлтэй танилцах боломжтой" гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.

### МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

..... оны ..... сарын .....-ны өдөр .....улсын  
.....хот/аймаг/мужид төрсөн

..... Улсын иргэн

### ШҮДНИЙ ИХ ЭМЧ, ХҮНИЙ ИХ ЭМЧ, УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ИХ ЭМЧ (аль нэгийг бичих)

..... /Ургийн овог/ ..... /эцэг/эхийн нэр/...../өөрийн нэр/-д

Эрүүл мэндийн сайдын ..... оны ..... сарын ..... өдрийн ..... дугаар тушаалаар ЭМЧЛЭХ үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл .... оны .....сарын .....-ны өдрөөс ..... оны ..... сарын .....-ны өдөр хүртэл ..... жилийн хугацаатай олгов.

Энэхүү зөвшөөрлийг .... оны .... сарын .....-ны өдөр ..... зөвшөөрлийн дахин давтагдашгүй дугаараар Эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд бүртгэв.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ.....

Огноо: ..... он ..... сар ..... өдөр

- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл олгосон тухайн эмнэлгийн мэргэжилтний 3х4 см зураг байрлуулна.
- Гэрчилгээг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын гарын үсэг, тамгаар албажуулна.



4. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.3-д заасан хугацаагаар бага эмчид олгох "Эмчлэх" үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичвэртэй байна:

- Гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Гэрчилгээ нь цайвар ногоон дэвсгэртэй, тод ногоон угалзан хээн хүрээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж "Монгол Улс", "Эрүүл мэндийн яам", "Эрүүл мэндийн хөгжлийн төв", түүний доод хэсэгт "Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ГЭРЧИЛГЭЭ" гэж бичсэн байна.
- Гэрчилгээний баруун доод буланд QR код байна.
- QR кодны доор "QR кодоор <http://hr.hdc.gov.mn/> цахим хуудаст хандаж, эмнэлгийн мэргэжилтний мэдээлэлтэй танилцах боломжтой" гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.

### МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

..... оны ..... сарын .....-ны өдөр .....улсын  
.....хот/аймаг/мужид төрсөн

..... Улсын иргэн

#### БАГА ЭМЧ

..... /Ургийн овог/ ..... /эцэг/эхийн нэр/...../өөрийн  
нэр/-д

Эрүүл мэндийн сайдын ..... оны ..... сарын ..... өдрийн  
..... дугаар тушаалаар ЭМЧЛЭХ үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл .... оны  
.....сарын .....-ны өдрөөс ..... оны ..... сарын .....-ны өдөр хүртэл ..... жилийн  
хугацаатай олгов.

Энэхүү зөвшөөрлийг .... оны .... сарын .....-ны өдөр ..... зөвшөөрлийн  
дахин давтагдашгүй дугаараар Эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд  
бүртгэв.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ.....

Огноо: ..... он ..... сар ..... өдөр

- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл олгосон тухайн эмнэлгийн мэргэжилтний 3x4 см зураг байрлуулна.
- Гэрчилгээг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын гарын үсэг, тамгаар албажуулна.



5. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.4-д заасан хугацаагаар эм зүйчид олгох "Эм барих" үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичвэртэй байна:

- Гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Гэрчилгээ нь цайвар шаргал дэвсгэртэй, гадуураа улбар шар өнгийн угалзан хээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж "Монгол Улс", "Эрүүл мэндийн яам", "Эрүүл мэндийн хөгжлийн төв", түүний доод хэсэгт "Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ГЭРЧИЛГЭЭ" гэж бичсэн байна.
- Гэрчилгээний баруун доод буланд QR код байна.
- QR кодны доор "QR кодоор <http://hr.hdc.gov.mn/> цахим хуудаст хандаж, эмнэлгийн мэргэжилтний мэдээлэлтэй танилцах боломжтой" гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.

### МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

..... оны ..... сарын .....-ны өдөр .....улсын  
.....хот/аймаг/мужид төрсөн

..... Улсын иргэн

#### ЭМ ЗҮЙЧ

..... /Ургийн овог/ ..... /эцэг/эхийн нэр/...../өөрийн  
нэр/-д

Эрүүл мэндийн сайдын ..... оны ..... сарын ..... өдрийн  
..... дугаар тушаалаар ЭМ БАРИХ үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл ..... оны  
.....сарын .....-ны өдрөөс ..... оны ..... сарын .....-ны өдөр хүртэл ..... жилийн  
хугацаатай олгов.

Энэхүү зөвшөөрлийг .... оны ... сарын .....-ны өдөр ..... зөвшөөрлийн  
дахин давтагдашгүй дугаараар Эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд  
бүртгэв

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ.....

Огноо: ..... он ..... сар ..... өдөр

- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл олгосон тухайн эмнэлгийн мэргэжилтний 3x4 см зураг байрлуулна.
- Гэрчилгээг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын гарын үсэг, тамгаар албажуулна.



6. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.4-д заасан хугацаагаар эм найруулагчид олгох "Эм барих" үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичвэртэй байна:

- Гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Гэрчилгээ нь цайвар шаргал дэвсгэртэй, гадуураа улбар шар өнгийн угалзан хээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж "Монгол Улс", "Эрүүл мэндийн яам", "Эрүүл мэндийн хөгжлийн төв", түүний доод хэсэгт "Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ГЭРЧИЛГЭЭ" гэж бичсэн байна.
- Гэрчилгээний баруун доод буланд QR код байна.
- QR кодны доор "QR кодоор <http://hr.hdc.gov.mn/> цахим хуудаст хандаж, эмнэлгийн мэргэжилтний мэдээлэлтэй танилцах боломжтой" гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.

### МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

..... оны ..... сарын .....-ны өдөр .....улсын  
.....хот/аймаг/мужид төрсөн

..... Улсын иргэн

### ЭМ НАЙРУУЛАГЧ

..... /Ургийн овог/ ..... /эцэг/эхийн нэр/...../өөрийн нэр/-д

Эрүүл мэндийн сайдын ..... оны ..... сарын ..... өдрийн  
..... дугаар тушаалаар ЭМ БАРИХ үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл .... оны  
.....сарын .....-ны өдрөөс ..... оны ..... сарын .....-ны өдөр хүртэл ..... жилийн  
хугацаатай олгов.

Энэхүү зөвшөөрлийг .... оны .... сарын .....-ны өдөр ..... зөвшөөрлийн  
дахин давтагдашгүй дугаараар Эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд  
бүртгэв.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ.....

Огноо: ..... он ..... сар ..... өдөр

- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл олгосон тухайн эмнэлгийн мэргэжилтний 3х4 см зураг байрлуулна.
- Гэрчилгээг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын гарын үсэг, тамгаар албажуулна.



7. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.5-д заасан хугацаагаар сувилагчид олгох "Сувилах" үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичвэртэй байна:

- Гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Гэрчилгээ нь улбар шар дэвсгэртэй, цайвар цагаан өнгийн өлзий хээн хүрээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж "Монгол Улс", "Эрүүл мэндийн яам", "Эрүүл мэндийн хөгжлийн төв", түүний доод хэсэгт "Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ГЭРЧИЛГЭЭ" гэж бичсэн байна.
- Гэрчилгээний баруун доод буланд QR код байна.
- QR кодны доор "QR кодоор <http://hr.hdc.gov.mn/> цахим хуудаст хандаж, эмнэлгийн мэргэжилтний мэдээлэлтэй танилцах боломжтой" гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.

### МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

..... оны ..... сарын .....-ны өдөр .....улсын  
.....хот/аймаг/мужид төрсөн

..... Улсын иргэн

### СУВИЛАГЧ

..... /Ургийн овог/ ..... /эцэг/эхийн нэр/...../өөрийн нэр/-д

Эрүүл мэндийн сайдын ..... оны ..... сарын ..... өдрийн  
..... дугаар тушаалаар СУВИЛАХ үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл .... оны  
.....сарын .....-ны өдрөөс ..... оны ..... сарын .....-ны өдөр хүртэл ..... жилийн  
хугацаатай олгов.

Энэхүү зөвшөөрлийг .... оны .... сарын .....-ны өдөр ..... зөвшөөрлийн  
дахин давтагдашгүй дугаараар Эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд  
бүртгэв.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ.....

Огноо: ..... он ..... сар ..... өдөр

- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл олгосон тухайн эмнэлгийн мэргэжилтний 3х4 см зураг байрлуулна.
- Гэрчилгээг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын гарын үсэг, тамгаар албажуулна.





8. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.6-д заасан хугацаагаар Эх баригчид олгох "Эх барих" үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичвэртэй байна:

- Гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Гэрчилгээ нь тод ягаан дэвсгэртэй, гадуураа цайвар шар өнгийн тариан түрүүн хээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж "Монгол Улс", "Эрүүл мэндийн яам", "Эрүүл мэндийн хөгжлийн төв", түүний доод хэсэгт "Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ГЭРЧИЛГЭЭ" гэж бичсэн байна.
- Гэрчилгээний баруун доод буланд QR код байна.
- QR кодны доор "QR кодоор <http://hr.hdc.gov.mn/> цахим хуудаст хандаж, эмнэлгийн мэргэжилтний мэдээлэлтэй танилцах боломжтой" гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.

### МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

..... оны ..... сарын .....-ны өдөр .....улсын  
.....хот/аймаг/мужид төрсөн

..... Улсын иргэн

#### ЭХ БАРИГЧ

..... /Ургийн овог/ ..... /эцэг/эхийн нэр/...../өөрийн нэр/-д

Эрүүл мэндийн сайдын ..... оны ..... сарын ..... өдрийн  
..... дугаар тушаалаар ЭХ БАРИХ үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл ..... оны  
.....сарын .....-ны өдрөөс ..... оны ..... сарын .....-ны өдөр хүртэл ..... жилийн  
хугацаатай олгов.

Энэхүү зөвшөөрлийг .... оны .... сарын .....-ны өдөр ..... зөвшөөрлийн  
дахин давтагдашгүй дугаараар Эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд  
бүртгэв.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ.....

Огноо: ..... он ..... сар ..... өдөр

- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл олгосон тухайн эмнэлгийн мэргэжилтний 3х4 см зураг байрлуулна.
- Гэрчилгээг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын гарын үсэг, тамгаар албажуулна.



9. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.7-д заасан хугацаагаар Сэргээн засахын мэргэжилтэнд олгох "Сэргээн засах" үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичвэртэй байна:

- Гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Гэрчилгээ нь усан цэнхэр дэвсгэртэй, тод цэнхэр угалзан хээн хүрээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж "Монгол Улс", "Эрүүл мэндийн яам", "Эрүүл мэндийн хөгжлийн төв", түүний доод хэсэгт "Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ГЭРЧИЛГЭЭ" гэж бичсэн байна.
- Гэрчилгээний баруун доод буланд QR код байна.
- QR кодны доор "QR кодоор <http://hr.hdc.gov.mn/> цахим хуудаст хандаж, эмнэлгийн мэргэжилтний мэдээлэлтэй танилцах боломжтой" гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.

### МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

..... оны ..... сарын .....-ны өдөр .....улсын  
.....хот/аймаг/мужид төрсөн

..... Улсын иргэн

### ХӨДӨЛГӨӨН ЗАСАЛЧ, ХӨДӨЛМӨР ЗАСАЛЧ, ХЭЛ ЗАСАЛЧ, СЭТГЭЛ ЗАСАЛЧ (аль нэгийг бичих)

..... /Ургийн овог/ ..... /эцэг/эхийн нэр/...../өөрийн нэр/-д

Эрүүл мэндийн сайдын ..... оны ..... сарын ..... өдрийн  
..... дугаар тушаалаар СЭРГЭЭН ЗАСАХ үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл  
..... оны .....сарын .....-ны өдрөөс ..... оны ..... сарын .....-ны өдөр хүртэл .....  
жилийн хугацаатай олгов.

Энэхүү зөвшөөрлийг .... оны .... сарын .....-ны өдөр ..... зөвшөөрлийн  
дахин давтагдашгүй дугаараар Эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд  
бүртгэв.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ.....  
Огноо: ..... он ..... сар ..... өдөр

- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл олгосон тухайн эмнэлгийн мэргэжилтний 3x4 см зураг байрлуулна.
- Гэрчилгээг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын гарын үсэг, тамгаар албажуулна.



10. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.9-д заасан хугацаагаар гадаадын их эмчид олгох "Эмчлэх" үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичвэртэй байна:

- Гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Гэрчилгээ нь нил ягаан дэвсгэртэй, ягаан угалзан хээн хүрээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж "Монгол Улс", "Эрүүл мэндийн яам", "Эрүүл мэндийн хөгжлийн төв", түүний доод хэсэгт "Гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ГЭРЧИЛГЭЭ" гэж бичсэн байна.
- Гэрчилгээний баруун доод буланд QR код байна.
- QR кодны доор "QR кодоор <http://hr.hdc.gov.mn/> цахим хуудаст хандаж, эмнэлгийн мэргэжилтний мэдээлэлтэй танилцах боломжтой" гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.

ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ МЭРГЭЖЛИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

..... оны ..... сарын .....-ны өдөр .....улсын  
.....хот/мужид төрсөн

..... Улсын харьяат

**МЭРГЭШСЭН ЭМЧ**

(хүний их эмч, шүдний их эмчтэй дүйцүүлж тухайн мэргэжлийг бичих)

.....-Д

Эрүүл мэндийн сайдын ..... оны ..... сарын ..... өдрийн  
..... дугаар тушаалаар ЭМЧЛЭХ үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл .... оны  
.....сарын .....-ны өдрөөс ..... оны ..... сарын .....-ны өдөр хүртэл .....  
хугацаатай олгов.

Энэхүү зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд Монгол Улсад ажиллах гэрээт  
эрүүл мэндийн байгууллагын нэр .....  
үзүүлэх төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээ  
.....-Г  
..... зөвшөөрлийн дахин давтагдашгүй дугаараар ..... оны .... сарын .....-ны  
өдөр ..... Эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд бүртгэв.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ.....

Огноо: ..... он ..... сар ..... өдөр

- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл олгосон тухайн эмнэлгийн мэргэжилтний 3x4 см зураг байрлуулна.
- Гэрчилгээг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын гарын үсэг, тамгаар албажуулна.



11. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.9-д заасан хугацаагаар гадаадын сувилагчид олгох "Сувилах" үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичвэртэй байна:

- Гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Гэрчилгээ нь нил ягаан дэвсгэртэй, ягаан угалзан хээн хүрээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж "Монгол Улс", "Эрүүл мэндийн яам", "Эрүүл мэндийн хөгжлийн төв", түүний доод хэсэгт "Гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ГЭРЧИЛГЭЭ" гэж бичсэн байна.
- Гэрчилгээний баруун доод буланд QR код байна.
- QR кодны доор "QR кодоор <http://hr.hdc.gov.mn/> цахим хуудаст хандаж, эмнэлгийн мэргэжилтний мэдээлэлтэй танилцах боломжтой" гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.

ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ МЭРГЭЖЛИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

..... оны ..... сарын .....-ны өдөр .....улсын  
.....хот/мужид төрсөн

..... Улсын харьяат

**СУВИЛАГЧ**

.....-Д

Эрүүл мэндийн сайдын ..... оны ..... сарын ..... өдрийн  
..... дугаар тушаалаар СУВИЛАХ үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл ..... оны  
.....сарын .....-ны өдрөөс ..... оны ..... сарын .....-ны өдөр хүртэл .....  
хугацаатай олгов.

Энэхүү зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд Монгол Улсад ажиллах гэрээт  
эрүүл мэндийн байгууллагын нэр .....  
үзүүлэх төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээ  
.....-Г  
..... зөвшөөрлийн дахин давтагдашгүй дугаараар ..... оны .... сарын .....-ны  
өдөр ..... Эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд бүртгэв.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ.....

Огноо: ..... он ..... сар ..... өдөр

- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл олгосон тухайн эмнэлгийн мэргэжилтний 3х4 см зураг байрлуулна.
- Гэрчилгээг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын гарын үсэг, тамгаар албажуулна.



12. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.9-д заасан хугацаагаар гадаадын сэргээн засахын мэргэжилтэнд олгох "Сэргээн засах" үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичвэртэй байна:

- Гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Гэрчилгээ нь нил ягаан дэвсгэртэй, ягаан угалзан хээн хүрээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж "Монгол Улс", "Эрүүл мэндийн яам", "Эрүүл мэндийн хөгжлийн төв", түүний доод хэсэгт "Гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ГЭРЧИЛГЭЭ" гэж бичсэн байна.
- Гэрчилгээний баруун доод буланд QR код байна.
- QR кодны доор "QR кодоор <http://hr.hdc.gov.mn/> цахим хуудаст хандаж, эмнэлгийн мэргэжилтний мэдээлэлтэй танилцах боломжтой" гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.

ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ МЭРГЭЖЛИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

..... оны ..... сарын .....-ны өдөр .....улсын  
.....хот/мужид төрсөн

..... Улсын харьяат

**ХӨДӨЛГӨӨН ЗАСАЛЧ, ХӨДӨЛМӨР ЗАСАЛЧ, ХЭЛ ЗАСАЛЧ, СЭТГЭЛ ЗАСАЛЧ**  
(аль нэгийг бичих)

.....-д

Эрүүл мэндийн сайдын ..... оны ..... сарын ..... өдрийн  
..... дугаар тушаалаар СЭРГЭЭН ЗАСАХ үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл  
..... оны .....сарын .....-ны өдрөөс ..... оны ..... сарын .....-ны өдөр хүртэл  
..... хугацаатай олгов.

Энэхүү зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд Монгол Улсад ажиллах гэрээт  
эрүүл мэндийн байгууллагын нэр .....  
үзүүлэх төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээ

.....-г  
..... зөвшөөрлийн дахин давтагдашгүй дугаараар ..... оны ... сарын .....-ны  
өдөр ..... Эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд бүртгэв.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ.....

Огноо: ..... он ..... сар ..... өдөр

- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл олгосон тухайн эмнэлгийн мэргэжилтний 3х4 см зураг байрлуулна.
- Гэрчилгээг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын гарын үсэг, тамгаар албажуулна.



13. Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний англи хувилбар нь дараах бичвэртэй байна:

CERTIFICATE OF LICENSE

Date of Birth: . . . day . . . . . month . . . year      Place of Birth: . . . city/province . . .  
.country

Nationality: .....

This is Certify that

Family name ..... Surname ..... First name.....

is a licensed

**Resident Physician/ Specialized Physician, Specialized Dentist, Traditional  
Medicine Physician/Dentist/ Physician/ Traditional Medicine Physician/Feldsher  
/Pharmacist /Pharmacist Assistant /Nurse /Midwife /Physical Therapist,  
Occupational Therapist, Speech Therapist, Psychotherapist**

by the Health Ministerial Order A/ . . . dated on . . . day . . . month . . . year.

LICENCE NO.

\_\_\_\_\_

EXPIRES:


. . . day . . . . . month . . . year

\_\_\_\_\_  
Director, Center for Health Development  
. . . day . . . month . . . year



А/295

Эрүүл мэндийн сайдын 2023 оны  
08 дугаар сарын 14-ны өдрийн  
дугаар тушаалын 5 дугаар хавсралт



## ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ТАНИЛЦУУЛГЫН МАЯГТ

### А. Гадаад улс дахь үндсэн эрүүл мэндийн байгууллагын мэдээлэл

1. Нэр
2. Хаяг
3. Цахим хуудас
4. Холбогдох утас, цахим хаяг
5. Хариуцах албан тушаалтан

3x4 см  
хэмжээтэй  
өнгөт цээж  
зураг

### Б. Монгол Улсад ажиллах эрүүл мэндийн байгууллагын мэдээлэл

1. Нэр
2. Хаяг
3. Цахим хуудас
4. Холбогдох утас, цахим хаяг
5. Хариуцах албан тушаалтан

### В. Гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэдээлэл

1. Нэр (паспорт, түүнийг орлох хууль ёсны баримт бичигт бичсэний дагуу)
2. Нас
3. Хүйс
4. Төрсөн улс
5. Үндсэн захиргаа
6. Паспортын дугаар, хүчинтэй хугацаа
7. Монгол Улсад зорчихоор мэдүүлэх визийн ангилал, төрөл
8. Мэргэжил
9. Төрөлжсөн мэргэшлийн чиглэл
10. Боловсролын зэрэг
11. Харьяалах гадаадын улсаас олгосон зөвшөөрлийн гэрчилгээний дугаар, олгосон огноо, хүчинтэй хугацаа
12. Эрхэлж байсан ажил (он дарааллаар):
13. Эрхэлж буй ажил, албан тушаал:
14. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан зөвшөөрлийн төрөл
15. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж ажиллахаар төлөвлөж буй хугацаа



16. Өмнө нь Монгол Улсад урт, богино хугацаагаар мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байсан түүх, зөвшөөрлийн огноо, дугаар (он дарааллаар)
17. Монгол хэлний түвшин тогтоох стандарт шалгалт (TOMFL-Test of Mongolian as a Foreign Language) өгсөн эсэх, монгол хэлний түвшин

Монгол талын эрүүл мэндийн  
байгууллагын дарга  
/Эцэг эхийн нэр, нэр/

.....  
гарын үсэг, тамга, тэмдэг

.....  
ОГНОО

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэн  
/паспорт, түүнийг орлох хууль ёсны  
баримт бичигт бичигдсэн нэр/

.....  
гарын үсэг, хувийн тамга буюу  
баталгааны тэмдэг

.....  
ОГНОО

